



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/517

Эргэнэт


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5/а/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит VI хуралдааны 6/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Эмч” дэд хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн IX хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн газрын Дархлаажуулалт, зоонозын өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Будсүрэнг Улаанбаатар хотноо 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 9 хоногийн хугацаатай Америкийн Нэгдсэн улсын “Lorno Linda” Их сургуулиас “Нийгмийн эрүүл мэндийн тархвар судлал, тандалтын арга зүй” сэдвээр зохион байгуулагдаж байгаа сургалтанд оролцуулан санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардалд шаардагдах 150000 /Нэг зуун тавин мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын 2018 оны “Эмч” хөтөлбөрийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/194 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд болон 3 дахь шатлалын эмнэлэгт эмч, эмнэлгийн ажиллагсадын ажил мэргэжлийн туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх” зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2018 оны
08 дугаар сарын 17-ны өдрийн 517
захирамжийн хавсралт



ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Шаардагдах зардал	Нэг бүрийн зардал /мян.төг/	Тоо	Нийт
1	Сургалтын төлбөр	100000	1	100000
2	Замын зардал /Эрдэнэт-Улаанбаатар-Эрдэнэт	25000	2	50000
	Дун			150000

00